



Брокер
Андеррайтер
Хөрөнгө оруулалтын зөвлөх

ЖИЛИЙН
ТАЙЛАН

2022

www.bdsec.mn



БидиСЕК ҮЦК нь 12 дахь удаагийн Global banking and finance awards-аар **“DECADE OF EXCELLENCE BROKERAGE MONGOLIA 2022”** болон **“DECADE OF EXCELLENCE INVESTMENT BANKING MONGOLIA 2022”**-иар тус тус шалгарсан.



**ДАНЗАН
ДАЯНБИЛГҮҮН** | ТУЗ-ийн дарга,
Ерөнхийлөгч

Эрхэм хүндэт
хувьцаа эзэмшигч,
хөрөнгө оруулагч
харилцагч
нар аа!

Та бүхэнд БидиСЕК ҮЦК ХК-ийн 2022 оны жилийн тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Манай компанийн хувьд харилцагчдад хүргэх үйлчилгээний чанарыг сайжруулж, зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүдийг санал болгосон амжилт ололтоор дүүрэн жил байлаа.

Бид өнгөрсөн жил Дэлхийн Банк санхүүгийн зах зээлийн томоохон төлөөлөгчдийн нэг болох “Global Banking and Finance Review” буюу “Дэлхийн Банк Санхүүгийн Тойм” байгууллагаас жил бүр зохион байгуулдаг “Global Banking and Finance Review” буюу “Дэлхийн Банк Санхүүгийн Тойм” байгууллагаас жил бүр зохион байгуулдаг “Global Banking and Finance Review Awards”-н “Сүүлийн 10 жилийн хугацаан дахь шилдэг брокер, дилерийн компани”, “Сүүлийн 10 жилийн хугацаан дахь шилдэг хөрөнгө оруулалтын банк”-аар шалгарав.

2021 оны 05 дугаар сараас эхлэн ХААН Банк ХХК-ийн нийтэд хувьцаагаа санал болгох ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар ажиллан, 2022 оны 04 сарын 22-ны өдөр үнэт цаасны бүрдүүлбэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Монголбанканд зэрэг хүргүүлсэн. 2022 оны 12 сарын 09-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэх зөвшөөрлийг авсан.

Компани нь 2022 оны сүүлийн хагас жилд биржийн бус зах зээл дээр бонд гаргах ажиллагаанд голчлон ажиллаж, Хүрэнтолгой Коал Майнинг ХХК, БИД ББСБ, Засагт Хаан ХХК зэрэг компаниудын хаалттай бондын ажиллагаанд андеррайтераар ажиллан 31.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Брокерийн үйл ажиллагааг илүү дижитал технологи дээр суурилан явуулахын тулд гарутасны аппликэйшн, веб-д хөгжүүлэлтг хийснээр онлайнаар данс нээх, гэрээ байгуулах, захиалга өгөх нөхцөлүүдийг илүү хялбарчлан хурдан шуурхай болгоход анхаарч ажиллаж байна.

2023 онд бид Хаан Банк болон бусад компаниудын энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагаатай уялдуулан харилцагчийн цар хүрээгээ тэлэх бодлого баримтлан, хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүнүүдийг санал болгон олон улсын жишигт нийцүүлэн ажиллахыг зорьж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



- 1 БидиСЕК ҮЦК ХК-ийн тэргүүлэх андеррайтераар ажиллаж буй ХААН Банкны нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэв.



- 2 Үндэсний давхар даатгал ХК-ийн нийтэд хувьцаагаа санал болгох ажиллагаанд андеррайтераар сонгогдов.

2022

01

КОМПАНИЙН ТУХАЙ



3

“Coal Mongolia” нүүрсний салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын Олон Улсын чуулга уулзалт, үзэсгэлэнд оролцов.



4

Биржийн бус зах зээлээс 3 компанийн хаалттай бонд бүхий 31.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэв.



ЛСЫН ХАРАА

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, технологид суурилсан санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжиж чинээлэг харилцагч, нийгмийн баялаг үнэт зүйлийг бий болгох.

ЗОРИЛГО

Урт хугацаанд

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох;

Дунд хугацаанд

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулах, хөрөнгийн зах зээлд оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх;

Богино хугацаанд

Гадаад харилцааг өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, компанийн боловсон хүчнийг чадваржуулах, харилцагчдыг хөрөнгийн зах зээлийн мэдээгээр найдвартай хангах;

Ү НЭТ ЗҮЙЛС



Хөрөнгийн зах зээлийн ууган
компани, зах зээлд анхдагч



Мэргэшсэн ур чадвартай,
туршлагатай баг хамт олон



Үйл ажиллагааны
ил тод байдал



Харилцагч төвтэй
үйлчилгээ



Боломжийг бүрэн
ашиглах чадвар

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



БҮРЭНМЭНД
ЛХАГВАДОРЖ
Гүйцэтгэх захирал



НАРАНГЭРЭЛ
БАТГЭРЭЛ
Тэргүүн дэд
захирал



ШАРАА
ШИНЭБАЯР
Дэд захирал



АЛИМАА
ЗОРИГ
Зөвлөх



СҮХБААТАР
ДАМДИНСҮРЭН
IT алба, Director



БАТ-ОРГИЛ
ОНОН
Харилцагчийн
алба, Director



ОДГИЙВ
УРАНБАЙГАЛ
Backoffice алба, VP



САМПИЛНОРОВ
ДӨЛГӨӨН
Харилцагчийн
алба, VP



ЭРДЭНЭТУЯА
ЭРХЭМЗАЯА
Хөрөнгө оруулалтын
алба, VP

2022



02

КОМПАНИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийт
судалсан
төсөл

37

“БидиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж буй компаниудын бизнесийг өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд хамтран ажиллаж байна. Компаниудын онцлог, үйл ажиллагаанаас хамааран түүнд тохирсон санхүүжилтийн хувилбарыг боловсруулан биржийн болон биржийн бус зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэхэд андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан.

Зөвлөгөө, мэдээлэл
хүргэсэн төсөл

70%

Шалгуур үзүүлэлтийг хангаагүй
буцаасан төсөл

16%

Амжилттай гэрээ байгуулсан,
хэрэгжүүлэхээр ажиллаж буй төсөл

14%

Судалсан төсөл
салбараар

САНХҮҮ

29.7%

УУЛ УУРХАЙ

18.9%

БАРИЛГА

10.8%

ХУДАЛДАА

13.5%

БОЛОВСРОЛ

2.7%

ҮЙЛДВЭРЛЭЛ

5.41%

БУСАД

16.2%



БАНКНЫ САЛБАРЫН ДИЙЛЭНХ ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТМОЛ БҮРДҮҮЛДЭГ САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧ КОМПАНИ

Монголын системийн нөлөө бүхий банкуудын нэг ХААН Банк ХХК-ийн андеррайтераар шалгаран, үнэт цаасны танилцуулгыг боловсруулж, 2022 оны 04 сарын 22-ны өдөр Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид материалыг зэрэг хүргүүлсэн.

Монголбанкнаас 2022 оны 07 сарын 27-ны өдөр, Монголын Хөрөнгийн Биржээс 09 сарын 09-ний өдөр IPO хийх зөвшөөрлийг авсан.

2022 оны 12 сарын 09-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос нийтэд санал болгож буй үнэт цаасыг бүртгэсэн.

Банкны сүүлийн 5 жилийн санхүүгийн үзүүлэлтээс харахад нийт актив жилд 16.9 хувиар, нийт зээл жилд 18.3 хувиар, нийт харилцах, хадгаламж жилд 22.5 хувиар өсч банкны салбар болон бусад системийн 4 банкнаас хурдацтайгаар өсөн нэмэгджээ.

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛСЫН ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ЭЗЭМШИГЧ КОМПАНИ

МУ-ын ЗГ-ын 2022 оны 6 сарын 29-ний өдрийн тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг гаргасан.

Тус тогтоолын дагуу Үндэсний давхар даатгал ХК-аас зарласан андеррайтер сонгон шалгаруулах тендерт оролцон шалгарснаар 2022 оны 9 сард андеррайтерийн гэрээ байгуулан ажиллалаа.



2 ИХ НАЯД ХҮРТЭЛХ ТӨГРӨГ, ДОЛЛАР ХОСОЛСОН НЭЭЛТТЭЙ БОНД

2022 оны 5 сард Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 76.6 тэрбум төгрөгийн нээлттэй бондыг транч 4-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар амжилттай зохион байгуулж татан төвлөрүүлсэн.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой.



АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨСЛИЙН ҮР АШИГ, АЧ ХОЛБОГДОЛ

Төслийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тодорхой хэсгээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг санхүүжүүлсний дүнд ашиглалтад орж, уул уурхайн бүтээгдэхүүнийг 2 дахин бага зардлаар тээвэрлэх боломжтой болов.

Нүүрс тээвэрлэлтийн өртөг буурах, шинэ гарц бий болох, нүүрсний экспорт нэмэгдэх

Санхүүгийн зохицуулах хорооны “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5-д тусгасан харилцааг зохицуулах журам Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 07 сарын 01-ний өдрийн 168 тоот тушаалаар батлагдсанаар БиДиСЕК ҮЦК ХК нь дараах төслүүдийг амжилттай хэрэгжүүлээд байна.

АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




2022 оны 6 сард Хүрэн Толгой Коал Майнинг ХХК-ийн биржийн бус зах зээл дээр бонд гаргах МҮЦАЭХ-ны бүртгэлийн хорооны зөвшөөрөл гарсан.

Үүний хүрээнд II транчийн 21.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.



БИД ББСБ ХХК нь 2022 оны 06 сард МҮЦАЭХ-ы бүртгэлийн хорооны 22/40 тоот тогтоолоор 3 тэрбум хүртэлх төгрөгийн үнэ бүхий өрийн хэрэгслийг ББЗЗ-ээр дамжуулан арилжаалах зөвшөөрлийг авсан.

Үүний хүрээнд II транчийн 1.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.




Засагт Хаан ХХК нь 2022 оны 12 сард МҮЦАЭХ-ны бүртгэлийн хорооны 22/78 тоот тогтоолоор 10 тэрбум хүртэлх төгрөгийн үнэ бүхий өрийн хэрэгслийг ББЗЗ-ээр дамжуулан арилжаалах зөвшөөрлийг авсан.

Үүний хүрээнд I транчийн 8.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.



2022 оны 12 сард Мөнхийн үсэг ХХК-тай байгуулсан андеррайтерийн гэрээний дагуу үнэт цаасны танилцуулга боловсруулах, бүртгүүлэхтэй холбоотой ажиллагааг гүйцэтгэж ажиллалаа.


Үүний хүрээнд I транчийн 3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.



Бид өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс хувьцаа, бонд худалдах, худалдан авах арилжаанд зуучилж, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг хүргэхээс гадна олон улсын хөрөнгийн биржээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах цогц үйлчилгээг хүргэж байна.


Нийт арилжаа /их наяд төгрөг/:

МХБ дээр нийт 1.16 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэний 17.9% буюу 207.8 тэрбум төгрөгийн арилжааг “БидиСЕК ҮЦК” ХК гүйцэтгэсэн байна.



Анхдагч зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг/:

2022 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд нийт 4 компани IPO хийж, 2 компани нэмж хувьцаа гаргаж, 3 компанийн бонд болон 6 компанийн ХБУЦ-ны арилжаа зохион байгуулагдсан. Компани нь ЭТТ нээлттэй бондын тэргүүлэх андеррайтераар ажилласан ба тайлант жил дэх анхдагч зах зээлийн арилжааны 22.2 хувийг гүйцэтгэсэн байна.



ҮНЭТ ЦААСНЫ ДАНС

ШИНЭЭР НЭЭГДСЭН ДАНС

1,914

Аж ахуйн нэгж

17

Хувь хүн

1,897

Дотоод харилцагч

1,910

Гадаад харилцагч

4

БРОКЕРИЙН ҮЙЛЭЖИЛЛЭГЭЭ

ОНЛАЙН БРОКЕР


Харилцагчид гар утас, компьютер, таблет зэргээрээ компанийн веб хөтөч, аппликейшнээр нэвтрэн ХААНААС Ч, ХЭЭЭЭ Ч Монголын Хөрөнгийн Биржийн арилжаанд оролцох, захиалгаа илгээх, дансны үлдэгдэл харах, гүйлгээ хийх боломжтой.

ОНЛАЙН БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Арилжааны шимтгэл

1%

Нийт арилжаанд оролцсон харилцагчдын тоо



Онлайнаар авсан захиалгын дүн /тэрбум ₮/



БиДиСЕК ҮЦК ХК-ийн онлайн арилжааны систем, гар утасны аппликэйшн нь дараах цэсийг багтаасан.

- ❖ Хяналтын самбар
- ❖ Дансны хуулга
- ❖ Гүйлгээний түүх
- ❖ Үлдэгдэл
- ❖ Мэдээ, мэдээлэл
- ❖ Өгөөжийн тооцоолол
- ❖ Ашгийн тооцоолол
- ❖ Миний багц /демо арилжаа/
- ❖ Арилжаа
- ❖ Мөнгө хүсэх өргөдөл


Дотоодын харилцагчдадаа олон улсын зах зээл дэх үнэт цаасны арилжаанд оролцох бололцоог бүрдүүлэх зорилготойгоор олон улсад тэргүүлэгч онлайн брокер Саксо Групптэй хамтран ажиллаж байна.

Саксо Банкаар дамжуулан 2022 онд 11,685 ам.долларын арилжаа хийгдэж, үүнээс 4,258,091 төгрөгийн шимтгэлийн орлого олжээ.

БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шинээр нээсэн данс

	Хувь хүн	ААН
2022	26	-
2021	25	1
2020	50	-
2019	34	-



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

www.agm.bdsec.mn



Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах вэб аппликэйшнийг өөрсдөө хөгжүүлснээр 8 хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ

ERDENE
RESOURCE DEVELOPMENT

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН



БОДЬ ДААТГАЛ



ХОТ ДЕВЕЛОПМЕНТ



Э-ТРАНС ЛОЖИСТИКС



ГОВИЙН ӨНДӨР



БАЯН ТЭЭГ



БОГД БАНК

ДОТООД СИСТЕМ
ХӨГЖҮҮЛЭЛТ

АНДЕРРАЙТЕР ТӨВТЭЙ АНХДАГЧИЙН

UaaS СИСТЕМ

Хаан банкны IPO-г
Андеррайтер төвтэй
зохион байгуулах
системийг
And Solutions -тай
хамтарч хөгжүүлсэн.

AND Solutions
Group company of AND Global

ВЕБ ХУУДАС БОЛОН ГАР УТАСНЫ АПЛИКЕЙШН ШИНЭЧЛЭЛТ

Компанийн веб хуудас болон гар утасны аппликейшний хөгжүүлэлт хийгдсэнээр харилцагчдадаа шинэчилсэн хувилбарыг санал болгож байна.



BDSCUP

“БидиСЕК ҮЦК” ХК-иас Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын дунд уламжлал болгон зохион байгуулдаг BDScup хөл бөмбөгийн тэмцээн 15 дахь удаагаа 2022 оны 9 сарын 17-ны өдөр амжилттай болж өндөрлөсөн.

Тэргүүн байр



Дэд байр



Гутгаар байр



Ерөнхий ивээн
тэтгэгч:



Ивээн тэтгэгч:



2022


03

КОМПАНИЙН
ЗАСАГЛАЛ

ОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компани нь дараах бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна. БиДиСЕК ҮЦК ХК-ийн 2022 оны 04 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ нь дараах 5 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдсон.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЕРДИЙН ГИШҮҮД



**ДАНЗАН
ДАЯНБИЛГҮҮН**

*ТУЗ-ийн дарга
2022.11 сараас
Ерөнхийлөгч,
БиДиСЕК ҮЦК ХК*



**БҮРЭНМЭНД
ЛХАГВАДОРЖ**

*Ердийн гишүүн
2022.11 сараас
Гүйцэтгэх захирал,
БиДиСЕК ҮЦК ХК*



**НАРАНГЭРЭЛ
БАТГЭРЭЛ**

*Ердийн гишүүн
2022.11 сараас
Тэргүүн дэд захирал,
БиДиСЕК ҮЦК ХК*



**УЛУЧ
БИНГОЛ**

*Ердийн гишүүн
Дэд захирал
Impera Capital*



**ОДГИЙВ
УРАНБАЙГАЛ**

*Ердийн гишүүн
Back office алба, VP
БиДиСЕК ҮЦК ХК*

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ХАРААТ БУС ГИШҮҮД



**ТАНИ
ХИТОШИ**

*Ерөнхийлөгч,
ЕХЕ корпораци*



**ДАРАМРАНЗ
АМГАЛАНБАЯР**

*Захиргааны
мэргэжилтэн,
MSM ХХК*



**БАЯРТОГТОХ
ЭНХБАЯР**

*Гүйцэтгэх захирал,
Санаа ЕХЕ ХХК*



**ОЧИР
ЛХАГВАСҮРЭН**

*Гүйцэтгэх захирал,
Сэцэн билгүүн ХХК*

БидиСЕК ҮЦК ХК-ийн
ТУЗ-ийн 2022 оны
05 сарын 13-ны
өдөр ТУЗ-ийн
дэд хороо дараах
бүрэлдэхүүнтэйгээр
томилогдсон.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭД ХОРООД

АУДИТЫН ХОРОО:

Дарга *Д.Амгаланбаяр*
Гишүүн *О.Лхагвасүрэн, О.Уранбайгал*

Хорооны чиг үүрэг:

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх явдлыг хангуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнал, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО:

Дарга *Д.Даянбилгүүн*
Гишүүн *Б.Энхбаяр, Улуч Бингол*

Хорооны чиг үүрэг:

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох ажлыг зохион байгуулах, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үндсэн чиг үүрэгтэй.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО:

Дарга *Н.Батгэрэл*
Гишүүн *Хитоши Тани, Д.Амгаланбаяр*

Хорооны чиг үүрэг:

Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж хянах, ТУЗийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үндсэн чиг үүрэгтэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ХУРЛЫН СТАТИСТИК

Огноо	Ирц	Баталсан ТОГТООЛЫН ТОО
2022.02.18	100%	1
2022.03.01	100%	1
2022.03.16	100%	4
2022.04.28	100%	1
2022.05.01	100%	1
2022.05.23	100%	6
2022.06.10	100%	1
2022.10.28	100%	1
2022.11.11	100%	2
Нийт		18

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалинг улирал бүр олгодог ба тус дүн нь татвар, хуулиар шаардсан бусад суутгалыг хасаагүй дүн болно.

	Сарын цалин	Жилийн цалин
ТУЗ-ийн гишүүдийн цалин /тус бүр/	500,000₮	6,000,000₮
ТУЗ-ийн НБД-ын цалин	300,000₮	3,600,000₮

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН КОМПАНИЙН ХУВЬ ЭЗЭМШИЛ

Гишүүн	Хувьцааны тоо	Хувь хэмжээ
Д.Даянбилгүүн	2,384,054	14.07%
Б.Лхагвадорж	465,436	2.75%
Н.Батгэрэл	328,014	1.94%
Д.Амгаланбаяр	332,129	1.97%
О.Уранбайгал	881	0.01%
Б.Энхбаяр	100	0.001%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


МХБ-ийн ангилал	I ангилал
Хаалтын ханш /2022.12.31/:	1,464
Зах зээлийн үнэлгээ /2022.12.31/:	20,049,308,712₮
Нийт эргэлтэнд гаргасан хувьцааны тоо:	13,694,883
52 долоо хоног	908₮-1,464₮

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



ХАНШ

/2022.01.04-2022.12.30/





04

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

PANTHER MIDLAND
AUDIT LLC
AUTHORIZED EXPERTS IN ACCOUNTING, AUDIT, CONSULTATION AND ASSESSMENT

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2023.04.02

№ 23/20

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“БИ ДИ СЕК ҮЦК” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Би Ди Сек ҮЦК” ХК болон түүний охин компани “Би Ди Си Эй Пи” ХХК, “Их Чингис Хааны хөмрөг” ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 12-28 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлангах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Номинал дансны талаар

“Би Ди Сек ҮЦК” ХК нь өөрийн харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий Худалдаа Хөгжлийн банканд байрших, 452644001 ам долларын, Голомт банканд байрших 1105391344 тоот ам долларын данс, Голомт банкны 1105057130 тоот төгрөгийн номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, байгууллагын “Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.


“Пантер Мидланд Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг


САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

№	Балансын үзүүлэлт	/Мянган төгрөг/	
		2022.01.01	2022.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	А.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	1,774,085.8	2,660,936.4
1.1.2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	14,776,608.1	26,172,741.3
1.1.3	Авлага	4,312,413.7	4,130,293.3
1.1.4	Бараа материал	-	-
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17,501.6	133,059.2
1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,880,609.2	33,097,030.2
1.2	Б.Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,414,284.3	4,381,510.3
1.2.2	Урт хугацаат хөрөнгө оруулалт	51,000.0	51,000.0
1.2.3	Биет бус хөрөнгө	12,547.9	40,864.3
1.2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,477,832.2	4,473,374.6
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,358,441.4	37,570,404.8
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	7,270,839.4	2,835,005.7
2.1.1.1	Дансны өглөг	5,705,826.8	1,156,799.4
2.1.1.2	Цалингийн өглөг	157,518.7	40,409.2
2.1.1.3	Татварын өр	149,834.1	25,441.4
2.1.1.4	НДШ - ийн өглөг	36,953.2	24,438.1
2.1.1.5	Богино хугацаат зээл	500,000.0	999,831.7
2.1.1.6	Хүүний өглөг	2,535.4	377,938.5
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	242.2	477.9
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	41,084.6	41,084.6
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	676,844.4	168,584.9
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	20,592,499.7
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	20,592,499.7
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,270,839.4	23,427,505.4
2.3	2.Эзэмшигчдийн өмч	13,151,322.0	12,551,128.1
2.3.1	Өмч: а) төрийн	-	-
2.3.2	б) хувийн	1,369,488.3	1,369,488.3
2.3.3	Нэмж төлөгдсөн капитал	7,957,309.3	7,957,309.3
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,824,524.4	3,824,524.4
2.3.5	Эздийн өмчийн бусад хэсэг	-	(600,193.9)
2.3.6	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4,936,280.0	1,591,771.3
2.3.7	Эзэмшигчдийн өмчийн дүн	18,087,602.0	14,142,899.4
2.4	Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	18,087,602.0	14,142,899.4
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,358,441.4	37,570,404.8

ОРЛОГЫН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	/Мянган төгрөг/	
		2022.01.01	2022.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн			
1.1.1	Үйл ажиллагааны орлого:	3,378,231.3	2,467,961.8
1.1.1.1	Брокерийн үйл ажиллагааны	474,456.4	209,782.7
1.1.1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	1,790,585.3	1,844,881.1
1.1.1.3	Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний орлого	354,630.0	20,716.1
1.1.1.4	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	758,559.6	392,582.0
1.1.1.5	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	-	-
1.1.2	Хөрөнгө оруулалтын орлого	332,566.6	995,780.7
1.1.2.1	Компанийн бондын хүүгийн орлого	-	-
1.1.2.2	Ногдол ашгийн орлого	179,786.3	149,583.7
1.1.2.3	Хүүний орлого	-	544,518.0
1.1.2.4	Бусад орлого	42,967.3	141,531.5
1.1.2.5	Түрээсийн орлого	109,813.0	160,147.4
1.1.1	Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	3,710,797.9	3,463,742.6
1.2	Борлуулсан хөрөнгө оруулалтын үнэт цаасны өртөг	-	-
1.3.	Нийт ашиг /алдагдал/	3,710,797.9	3,463,742.6
1.4.	Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирдлага/-ын зардал	2,515,447.0	3,592,589.2
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	1,195,350.9	(128,846.6)
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдлын дүн/	562,195.0	(3,215,510.3)
3	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	1,757,545.9	(3,344,356.9)
3.1	Орлогын татварын зардал	123,017.1	151.8
4	Татварын дараахь ашиг /алдагдал/	1,634,528.8	(3,344,508.7)
5			
6	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	1,634,528.8	(3,344,508.7)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2022.01.01	/Мянган төгрөг/ 2022.12.31
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,325,420.4	14,338,532.4
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,479,442.4	(12,512,437.5)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,587,461.0)	(939,244.4)
Валютын ханшны зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,217,401.8	886,850.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	556,684.0	1,774,085.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,774,085.8	2,660,936.4

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488.3	7,957,309.3	3,824,524.4	-	3,301,751.1	16,453,073.1
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488.3	7,957,309.3	3,824,524.4	-	4,936,280.0	18,087,602.0
Залруулсан үлдэгдэл	1,369,488.3	7,957,309.3	3,824,524.4	-2,977,265.7	4,936,279.9	31,238,924.0
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-3,344,508.7	-3,344,508.7
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488.3	7,957,309.3	3,824,524.4	-600,193.9	1,591,771.3	14,142,899.4

ОРЛОГЫН ТАЙЛАН

Компани нь 2022 оны аудитлагдсан тайлангийн үр дүнгээр 3.34 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан үзүүлэлттэй байна.

Тус алдагдалд компанийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарз, үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн гарз зэрэг бодит бус зардлууд гол нөлөөлсөн.

Үндсэн үйл ажиллагааны хувьд компани нь 2022 онд төлөвлөсөн төслүүд гадаад хүчин зүйлээс шалтгаалан хойшилсонтой холбоотой 262 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

АЛДАГДАЛД НӨЛӨӨЛСӨН ГОЛЛОХ ХҮЧИН ЗҮЙЛС:

Үнэт цаасны
үнэлгээний
тэгшитгэлийн
гарз

2.2 тэрбум
төгрөг

Банкны реформын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудын IPO тус онд зохион байгуулагдахаар төлөвлөгдөж байсан. Гэвч Банкны тухай хуулийн хүрээнд тус хугацааг хойшилсон нь хөрөнгө оруулагчдын хувьд тодорхойгүй нөхцөл байдал үүссэн. Банкуудын IPO хөрөнгийн зах зээлийн оролцогчдын дунд хүлээлт их байсантай холбоотойгоор 2022 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх сул, хөрвөх чадвар муу байлаа. Энэ нь хувьцаануудын ханш буурахад голчлон нөлөөлсөн.

Гадаад валютын
ханшийн
тэгшитгэлийн
гарз

983 сая
төгрөг

Компани нь хөрөнгө оруулалтын зориулалтаар 5 сая ам.долларын зээл авсан.

Тайлант жилийн хугацааны төгсгөлд тус зээлийн хүүгийн зардлыг тайлант өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлж бүртгэхэд бодит бус зардал гарсан.



 **БидиСЕК ХК**
УНӨТ ЦААСНЫ КОМПАНИ

Брокер
Андеррайтер
Хөрөнгө оруулалтын зөвлөх

Хаяг: БидиСек ХК,
Бээжингийн гудамж 27/1,
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот Монгол улс.

Утас: +976 7555-1919

И-мэйл: info@bdsec.mn

Вэб: www.bdsec.mn